

СУДАЛГАДНА

ХҮНИЙ
ХУВИЙН
МЭДЭЭЛЛИЙГ
АШИГЛАХ НЬ



ТУНГААХУЙ ӨГӨГДЛИЙН УРЛАН
www.tungaahui.mn
[@tungaahui](https://www.instagram.com/tungaahui)

© Тунгаахуй өгөгдлийн урлан ХХК, 2026



Энэхүү гарын авлагыг зохиогчийг дурдах нөхцөлтэйгөөр бүтнээр болон хэсэгчлэн чөлөөтэй ашиглах, хуулах, нийтлэх, түгээх боломжтой.

СУДАЛГААНД ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ НЬ

ГАРЫН АВЛАГА




СУДАЛГАА БА ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ



СУДАЛГААНЫ ГОЛ ТҮҮХИЙ ЭД БОЛ
“ӨГӨГДӨЛ”. ХАРИН ТЭРХҮҮ ӨГӨГДЛИЙН
ЦААНА ИХЭНХДЭЭ БОДИТ ХҮНИЙ ХУВИЙН
МЭДЭЭЛЭЛ ОРШДОГ.

Хүний оролцоотой судалгаа хийх явцад нас, хүйс,
боловсрол, эрүүл мэндийн байдал, үзэл бодол,
амьдралын хэв маяг зэрэг хувь хүнийг шууд болон шууд
бусаар таних боломжтой **хувийн мэдээлэл** цуглуулах,
ашиглах шаардлага үүсдэг.



Хүний хувийн мэдээлэл бол тухайн хүний хувийн орон зай, аюулгүй байдал, халдашгүй байх эрхтэй холбоотой чухал ойлголт.

Судалгааны үнэ цэн зөвхөн гарсан үр дүнгээр хэмжигдэх бус, хүний хувийн мэдээлэлтэй хэр харьцууцлагатай ажилласнаар үнэлэгдэнэ.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ СУДЛААЧИЙН ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА

Хүний оролцоотой судалгааг төлөвлөх,
хэрэгжүүлэх, тайлагнах бүхий л үе шатанд
судлаачид ёс зүйн болон эрх зүйн чухал үүрэг,
хариуцлага хүлээдэг.



СУДЛААЧ НЬ МЭДЭЭЛЛИЙГ
ОРОЛЦОГЧИЙН **ЗӨВШӨӨРӨЛТЭЙ**
АШИГЛАХ ҮНДСЭН ҮҮРЭГТЭЙГЭЭС
ГАДНА **ХУВИЙН НУУЦ, АЮУЛГҮЙ**
БАЙДАЛ, ЭРХИЙГ ХАМГААЛАХ
ЁСТОЙ.

ЭДГЭЭР ХАРИУЦЛАГА НЬ
СУДАЛГААНЫ ЗАГВАР, АРГА ЗҮЙ,
САЛБАР ЗЭРГЭЭС ҮЛ ХАМААРАН
ХҮНИЙ ОРОЛЦООТОЙ БҮХ ТӨРЛИЙН
СУДАЛГААНД ХАМААРНА.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Хувийн мэдээлэл,
нууцлалыг хамгаалах
нь хүний суурь эрхэд
тооцогддог.

ОЛОН УЛСАД:

→ ХУВИЙН НУУЦ БОЛ ХҮНИЙ ЭРХ

1948 онд НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалд **хүний хувийн нууцыг хамгаалах нь хүний үндсэн эрхийн нэг болохыг** хүлээн зөвшөөрсөн.

→ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ОРЧИН ҮЕИЙН ХАМГИЙН ХҮЧТЭЙ ЗОХИЦУУЛАЛТ - GDPR

Европын холбооны “Мэдээлэл хамгаалах ерөнхий журам” (General Data Protection Regulation) нь хүний хувийн мэдээллийг хамгаалах орчин үеийн хамгийн чухал эрхзүйн зохицуулалтын нэг юм.

Энэхүү зохицуулалт хэрэгжсэнээр **хүний хувийн мэдээллийг хамгаалах олон улсын жишиг** шинэ түвшинг хүрч, байгууллагууд мэдээлэлтэй илүү хариуцлагатай харьцах үүрэгтэй болсон төдийгүй иргэд өөрийн мэдээлэлдээ илүү бодит хяналт тавих боломжтой болсон.

GDPR-ийн зарчим, стандартыг зөвхөн Европын улсууд төдийгүй бусад олон улс, байгууллагууд хувийн мэдээлэл хамгаалах жишиг болгон ашиглаж байна.

МОНГОЛ УЛСАД:



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ


1992 онд батлагдсан **Монгол Улсын Үндсэн хууль** хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, иргэний хувийн амьдрал, захирал харилцаа, орон байрны нууцыг хуулиар хамгаална гэж заасан.



ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

2021 онд **Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль** тэргүүтэй багц хуулиудыг баталснаар хүний хувийн мэдээллийг илүү нарийн зохицуулалтаар хамгаалах эрхзүйн орчин бүрдсэн. Эдгээр хуульд хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, хадгалах, дамжуулахдаа тухайн хүний зөвшөөрлийг авах, нууцлалыг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах үүргийг тодорхойлсон.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?



Хүний хувийн мэдээлэл нь тухайн хүний нууцлал, аюулгүй байдал, нэр төртэй шууд холбоотой.



ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ГЭЖ
ХҮНИЙГ **ШУУД БОЛОН ШУУД**
БУСААР ТОДОРХОЙЛОХ, ЭСХҮЛ
ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖТОЙ
МЭДЭЭЛЭЛ ЮМ.

Хувийн мэдээлэл нь хүнийг тодорхойлох, таних боломж олгодог тул нууцлал, аюулгүй байдлыг нь хамгаалах шаардлагатай мэдээлэл болдог.

СУДАЛГААНД ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ НЬ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

1. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ

Хүн бүр өөрийн хувийн мэдээллийг хэрхэн, ямар зорилгоор, хэнд ашиглуулахыг мэдэх, шийдэх эрхтэй. Хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй, буруу ашиглах нь хүний хувийн орон зайг халгах, нууцлал, эрхийг зөрчих эрсдэлтэй.

2. АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ


Хувийн мэдээлэл алдагдах, хангалттай хамгаалагдахгүй байх тохиолдолд залилан, санхүүгийн хохирол, цахим халдлага, нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, ялгаварлан гадуурхалт зэрэг олон төрлийн хохирол үүсэж болно.

3. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШААРДЛАГЫГ ДАГАХ

Монгол Улсад болон олон улсын түвшинд хүний хувийн мэдээллийг хамгаалах хууль, эрх зүйн зохицуулалтууд хэрэгждэг. Судлаач болон судалгааны байгууллага нь эдгээр шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

4. СУДАЛГААНЫ ЧАНАР БА ЁС ЗҮЙ

Хувийн мэдээлэл нь хамгаалагдсан гэж үзсэн үед оролцогчид илүү итгэлтэй оролцож, үнэн зөв мэдээлэл өгөх хандлага нэмэгддэг. Энэ нь судалгааны чанар, үр дүнгийн найдвартай байдлыг сайжруулж, судалгааны ёс зүйн зарчмыг хангахад чухал ач холбогдолтой.



ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛД ЯМАР МЭДЭЭЛЛҮҮД БАГТАХ ВЭ?



Судалгааны явцад тухайн хүнийг **шууд** эсвэл **шууд бусаар таних боломжтой** бүхий л мэдээлэл хувийн мэдээлэлд тооцогдоно. Тухайлбал, хүний нэр, регистрийн дугаар, утасны дугаар, зураг, видео бичлэг зэрэг нь хүнийг шууд таних боломжтой мэдээлэлд хамаарна. Харин нас, хүйс, ажил мэргэжил, гэр бүлийн байдал зэрэг нь шууд бусаар буюу дангаараа хүнийг таних боломжгүй ч бусад мэдээлэлтэй нийлбэл таних боломжтой мэдээлэл байж болно.

Мөн эрүүл мэндийн мэдээлэл, биометрик мэдээлэл, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол зэрэг нь хүний эмзэг, нууц мэдээлэлд хамаарах бөгөөд ийм төрлийн мэдээлэл нь илүү өндөр түвшний нууцлал, хамгаалалт шаардана.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2021)-г хүний хувийн мэдээлэл, түүнд хамаарах эмзэг мэдээлэл, нууц мэдээллийг тодорхойлж өгсөн.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

Хүнийг шууд эсвэл шууд
бусаар таних боломжтой
аливаа мэдээлэл.



ХҮНИЙ ЭМЗЭГ МЭДЭЭЛЭЛ

Алдагдах эсвэл зөвшөөрөлгүй ашиглагдах
тохиолдолд хүний эрх, аюулгүй байдал, нэр
хүндэд эрсдэл учруулж болох мэдээлэл.

Хүний нүүд мэдээлэл

Үндэс угсаа

Шашин шүтлэг

Итгэл үнэмшил

Ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх

ХҮНИЙ НУУЦ МЭДЭЭЛЭЛ

Бусдаг загруулахгүй
хамгаалах ёстой мэдээлэл.

имэйл, шуудан,
илгээмж, чат, мессеж,
дуудлага, файл, зураг,
видео илгээсэн түүх

Захидал харилцааны мэдээлэл

Эрүүл мэндийн мэдээлэл

өвчний түүх, онош,
шинжилгээний хариу,
эрүүл мэндийн үйлчилгээ
авсан тухай мэдээлэл

хурууны хээ, нүүр царай,
нүдний солонгон бүрхэвч,
дуу хоолой, алхаа,
хөдөлгөөний хэв маяг
зэрэг биеийн давхцахгүй
өгөгдөл

Биометрик мэдээлэл

хүний ДНХ, удамшил,
биологийн онцлогтой
холбоотой дахин
давтагдашгүй мэдээлэл

Генетик мэдээлэл

Бэлгийн харьцааны талаарх мэдээлэл

Бэлгийн болон хүйсийн чиг баримжаа

Тоон гарын үсгийн хувийн түлхүүр

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛД ЯМАР МЭДЭЭЛЛҮҮД БАГТАХ ВЭ?

Судалгааны санал асуулгын
хуудас, анкет, цахим
маягтаар оролцогчийн
бөглөсөн мэдээлэл

Судалгааны явцад авсан
хэмжилт, туршилтын өгөгдөл
(жишээ нь, тархины зураг,
зүрхний хэмнэл, биометрик болон
физиологийн үзүүлэлтүүд)

Утас, ганцаарчилсан ярилцлага,
бүлгийн ярилцлага зэрэг аргаар
мэдээлэл цуглуулах үед хийсэн аудио
болон видео бичлэг, тэдгээрийн
хөрвүүлсэн бичвэр, тэмдэглэл

Судлаачийн оролцогчийн
талаар хийсэн ажиглалт,
талбарын тэмдэглэл

Судалгаанд оролцогчийн
тухай цуглуулж буй
аливаа мэдээлэл нь
дангаараа эсвэл бусад
мэдээлэлтэй нийлж,
тухайн хүнийг шууд
болон шууд бусаар
таних боломжтой
бол хувийн мэдээлэлд
тооцогдоно.

Байгууллагын бүртгэл, мэдээллийн
сангаас авсан мэдээлэл.
(Статистикийн мэдээлэл, төрийн
байгууллага, архив, эмнэлэг,
сургуулиас авсан мэдээлэл гэх мэт)

Нийгмийн сүлжээ, форум,
олон нийтэд нээлттэй
цахим орчноос цуглуулсан
хэрэглэгчийн контент,
сэтгэгдэл, нийтлэл,
харилцааны өгөгдөл

Онлайн судалгаа, ухаалаг төхөөрөмж
ашигласан судалгааны явцад
автоматаар бүртгэгдсэн өгөгдөл. (IP
хаяг, байршлын мэдээлэл, төхөөрөмж
болон интернет холболтын мэдээлэл,
хэрэглээний түүх, аппликейшн болон
веб сайтын хэрэглээний бүртгэл,
хөдөлгөөний болон мэдрэгчийн
өгөгдөл гэх мэт)

Гуравдагч этгээдээр дамжуулан
авсан өгөгдөл. (Судалгааны
байгууллага, цахим платформ, өмнө
хийгдсэн судалгааны өгөгдлийн
сангаас дамжуулан ашиглах
мэдээлэл)

Судалгаанд оролцох
зөвшөөрлийн маягт,
бүртгэлийн баримт
бичиг гэх мэдээлэл

СУДАЛГААНД ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ АШИГЛАХ ЗАРЧИМ

Европын холбооны GDPR-г тусгасан хувийн мэдээлэл боловсруулах үндсэн зарчмууд нь хувь хүний мэдээллийг хамгаалах суурь шаардлагуудыг тодорхойлдог. Иймд судалгааны явцад хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой үйл ажиллагаанд эдгээр зарчмыг баримтлах нь зохистой.

Түүнчлэн Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2021)-г хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад баримтлах үндсэн зарчмуудыг тодорхойлсон байдаг.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ (2021)

5.1.1. хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх;

5.1.2. хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

5.1.3. ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.4. мэдээллийг хуульд заасан үндэслэлээр, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу цуглуулах, боловсруулах, ашиглах;

5.1.5. мэдээллийн аюулгүй байдлыг хангах;

5.1.6. мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх.

GENERAL DATA PROTECTION REGULATION (EUROPEAN UNION)

1. Хууль ёсны, шударга
бөгөөд ул тог байх
Lawfulness, fairness and
transparency

Хувийн мэдээллийг мэдээллийн эзний
зөвшөөрөлд үндэслэн, хууль ёсны
дагуу цуглуулж, ашиглах

2. Зорилгын хязгаарлалт
Purpose limitation

Мэдээллийг зөвшөөрсөн зорилгын
хүрээнд ашиглах

3. Өгөгдлийн минималчлал
Data minimization

Зөвхөн шаардлагатай хэмжээний
мэдээлэл цуглуулах

4. Нарийвчлал ба үнэн зөв байдал
Accuracy

Үнэн зөв, шинэчлэгдсэн, бүрэн бүтэн
мэдээлэл ашиглах

5. Хадгалалтын
хугацааны хязгаарлалт
Storage limitation

Мэдээллийг зөвхөн шаардлагатай
хугацаанд хадгалах

6. Бүрэн бүтэн байдал ба нууцлал
Integrity and confidentiality

Хувийн мэдээллийн аюулгүй байдлыг
хангах

7. Хариуцлага
Accountability

Хариуцлага хүлээх

СУДАЛГААНД ХУВИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ОРОЛЦОГЧ ТАЛУУД



МЭДЭЭЛЛИЙН ЭЗЭН

Судалгаанд оролцогч
Мэдээллээр
тодорхойлогдож байгаа
хүн буюу хувийн мэдээлэл нь
хамаарч буй хүн



МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧ

Судалгааны байгууллага, судлаач
Мэдээллийн эзний зөвшөөрлийн
гагуу мэдээлэл цуглуулж,
боловсруулж, ашиглаж байгаа хүн,
хуулийн этгээд



МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАГЧ

Гэрээний үндсэн дээр Мэдээлэл
хариуцагчаас мэдээлэл цуглуулах,
боловсруулах үүргийг шилжүүлж
авсан этгээд



МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЭРХ, ҮҮРЭГ



Хүний хувийн мэдээллийн аюулгүй байдал, хамгаалуулах эрх нь Монгол Улсын Иргэний хуульд заасан “ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХ” болон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан “ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ”-ээр хуульчлан баталгаажсан.



ЭРХ:

ЗӨВШӨӨРӨЛ ӨГӨХ

Сайн дурын үндсэн дээр мэдээлэл
хариуцагчид мэдээллээ өгөх,
өгөхөөс татгалзах

МЭДЭХ

Өөрт хамааралтай ямар мэдээллийг
хэн, ямар зорилгоор цуглуулж байгаа, хэр
удаан ашиглах, хэрхэн хамгаалах, бусдаг
гамжуулах эсэх зэргийг тодорхой мэдэх

МЭДЭЭЛЛЭЭ ЗАЛРУУЛАХ

Алдаатай мэдээллийг залруулах талаар
мэдээлэл хариуцагчид мэдэгдэж өөрчлөлт
оруулах, нэмэлт мэдээлэл өгч тусгуулах

МЭДЭЭЛЛЭЭ УСТГУУЛАХ БУЮУ МАРТАГДАХ

Өөрийн мэдээллийг устгуулах талаар
мэдээлэл хариуцагчид мэдэгдэж устгуулах
мартагдах



ҮҮРЭГ:

Хувийн мэдээллээ
хамгаалах

Мэдээллийнхээ үнэн
зөв байдлыг хангах

Алдаатай мэдээлэл
байвал залруулах

Өөрийн мэдээллийг
ашиглахдаа бусдын эрхийг
зөрчихгүй байх

МЭДЭЭЛЛИЙН ХУУЛБАРЫГ АВАХ

Өөрт хамааралтай
мэдээллийн хуулбарыг мэдээлэл
хариуцагчаас авах

ГОМДОЛ/ТАЙЛБАР ГАРГАХ

Мэдээллийг боловсруулсны үр дүнд гарсан
шийдвэрт гомдол, тайлбар гаргах,
нэмэлт мэдээллийг оруулах, мэдээллийг
дахин боловсруулахыг шаардах эрхтэй.

ХҮССЭН ҮЕДЭЭ ЗӨВШӨӨРЛӨӨ ЦУЦЛАХ

Мэдээлэл цуглуулах, боловсруулах,
ашиглах үйл ажиллагааны явцад цуцлах
хүсэлт гаргах цуцлах хүсэлт гаргах

ХУВИЙН МЭДЭЭЛЛЭЭ ХАМГААЛУУЛАХ

Өөрийн хувийн мэдээллийг хуулийн хүрээнд
хамгаалуулах, эрх нь зөрчигдсөн гэж үзвэл
эрхээ хамгаалуулах, хохирол учирсан бол
арилгуулах



МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧИЙН ҮҮРЭГ



Хүний хувийн мэдээлэл
хамгаалах тухай хуульд заасны
дагуу мэдээлэл хариуцагчийн
үүрэг нь хуульчлан
тодорхойлогдсон.

МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЗӨВШӨӨРӨЛ

- Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, бусдад дамжуулахдаа мэдээллийн эзнээс зөвшөөрөл авна.
- Мэдээллийн эзэнд зөвшөөрлөө хүссэн үедээ хялбар, ойлгомжтой байдлаар цуцлах боломж олгоно.

МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

- Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авахдаа шаардлагатай мэдээллийг бүрэн өгч, мэдээлэлтэй зөвшөөрөл авна.
- Мэдээллийн эзний хүсэлтийн дагуу мэдээлэл боловсруулах, ашиглах үйл ажиллагааны талаар мэдээлэл өгнө.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

- Хувийн мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, аюулгүй хадгалалтыг хангаж, зөвшөөрөлгүй хандалт, алдагдалаас хамгаална.
- Мэдээлэл алдагдсан, зөрчил илэрсэн тохиолдолд харцу арга хэмжээ авч, мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөхөөр бол даруй мэдэгдэнэ.
- Мэдээллийг зөвхөн шаардлагатай хугацаанд хадгалж, зорилго биелсэн бол эсвэл мэдээллийн эзний хүсэлтээр устгана.

МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ

- Мэдээллийн эзэн өөрийн мэдээлэлтэй танилцах, хуулбар авах боломж олгоно.
- Мэдээллээ засуулах, устгуулах, зөвшөөрлөө цуцлах, гомдол гаргах боломжоор хангана.
- Мэдээллийн эзний хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн, харцу мэдэгдэнэ.

ЁС ЗҮЙ БА ХАРИУЦЛАГА

- Хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэнэ.
- Ялгаварлан гадуурхахгүй байна.
- Хувийн мэдээлэл хамгаалах хууль, журмыг мөрдөнө.
- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагаанд харцуцлага хүлээнэ.



МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

- Зөвхөн мэдээллийн эзний өгсөн зөвшөөрлийн хүрээнд мэдээлэл хариуцагчийн хяналт доор ажиллах
- Мэдээллийн нууцлалыг хадгалах
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, зөрчил илэрсэн тохиолдолд мэдээлэл хариуцагчид мэдэгдэх
- Зорилго биелсний дараа мэдээллийг хуулбар үлдээлгүй буцаан өгөх, дахин ашиглах боломжгүйгээр устгах



МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦАГЧИЙН БАТАЛЖ МӨРДӨХ ЖУРАМ, ХӨТЛӨХ БҮРТГЭЛ

ЖУРАМ

- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны журам
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам
- Мэдээлэл ашиглахыг хязгаарлах, мэдээллийг устгах, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар журам

БҮРТГЭЛ

- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны бүртгэл
- Мэдээлэл цуглуулах, боловсруулахад илэрсэн зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээний бүртгэл



ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Мэдээлэл хариуцагч нь мэдээлэл боловсруулах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах зорилгоор үнэлгээ хийж болно. Ялангуяа хүний оролцоогүй цахим боловсруулалтын үр дүнд мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөх шийдвэр гаргах, эсхүл хүний эмзэг мэдээллийг байнга боловсруулах тохиолдолд үнэлгээ хийнэ.



ЗӨВЛӨМЖ АВАХ

Хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотойгоор хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хүний эрхийн Үндэсний Комиссоос зөвлөмж авч болно.

СУДАЛГААНД ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ АЖИЛЛАХ ЗАМЫН ЗУРАГ

Хүний оролцоотой судалгааны бүхий л үе шатанд хувийн мэдээллийг судалгааны ёс зүй, мэдээллийн аюулгүй байдал, хууль эрхзүйн шаардлагад нийцүүлэн хамгаалах шаардлагатай. Хувийн мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа нь судалгааны салшгүй хэсэг юм.



1. ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН
АМЬДРАЛЫН МӨЧЛӨГИЙГ
ТӨЛӨВЛӨХ

2. ХУВИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ
ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН
ҮНДЭСЛЭЛИЙГ ХАНГАХ

3. ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ
ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ

4. ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ
БОЛОВСРУУЛАХ

5. ҮР ДҮНГ НИЙТЛЭХ,
ХУВААЛЦАХ

6. ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ
УСТГАХ

1.

ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН АМЬДРАЛЫН МӨЧЛӨГИЙГ ТӨЛӨВЛӨХ



Судалгааг эхлүүлэхийн өмнө судалгаанг ашиглах хувийн мэдээллийг нарийн төлөвлөх шаардлагатай. Мэдээлэл хамгаалахтай холбоотой үндсэн шийдвэрүүдийг тогтоож, судалгааны туршид тууштай хэрэгжүүлнэ.

СУДАЛГААНД ХУВИЙН
МЭДЭЭЛЭЛ АНХНААСАА
ХАМГААЛАГДСАН БАЙНА.

БҮГДИЙГ ЭХЛЭЭД ТӨЛӨВЛӨ!

1. Судалгаанд
ямар хувийн
мэдээлэл
ашиглах вэ?

2. Хувийн
мэдээллийг
хэрхэн
аюулгүй
цуглуулах вэ?

3. Цуглуулсан
мэдээллийг
хэрхэн
аюулгүй
хадгалах вэ?

7. Судалгаа
дууссаны дараа
мэдээллийг
хэрхэн аюулгүй
устгах вэ?

6. Судалгааны
үр дүнг
хэрхэн
нийтлэх,
хуваалцах вэ?

5. Хэн
мэдээлэлд
хангах
эрхтэй
байх вэ?

4. Хувийн
мэдээллийг
хэрхэн
аюулгүй
боловсруулах
вэ?

САНАМЖ

- Судалгааны зорилготой уялдуулан зөвхөн шаардлагатай хамгийн бага хэмжээний мэдээлэл цуглуулахаар төлөвлөх
- Судалгааны бүхий л үе шатанд хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах
- Судалгааны багт хувийн мэдээлэл хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлын талаар зааварчилгаа өгөх

2.

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛИЙГ ХАНГАХ



Судалгааны онцлог, хэрэгцээнг үндэслэн хүний хувийн мэдээлэл цуглуулах, ашиглахад шаардлагатай баримт бичгүүдийг бэлтгэнэ.

Мэдээлэлтэй зөвшөөрөл (Informed consent)

- Судалгаанд оролцогчдог судалгааны зорилго, цуглуулах мэдээлэл, боломжит эрсдэл, үр ашиг, хувийн мэдээллийг хэрхэн ашиглах, хадгалах талаар мэдээлэл өгч, сайн дурын үндсэн дээр зөвшөөрөл авах баримт бичиг.

САНАМЖ:

- Хувийн мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлд үндэслэн цуглуулж, ашиглана.
- Хувийн мэдээллийг ашиглахдаа хүний хувийн орон зай, аюулгүй байдал, халдахгүй байх эрхийг хамгаална.

Мэдээлэл хариуцагчийн баталж мөрдөх журмууд

- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны журам
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам
- Мэдээлэл ашиглахыг хязгаарлах, мэдээллийг устгах, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар журам

Хувийн мэдээлэл боловсруулахтай холбоотой эрсдэлийн үнэлгээ

- Хүний оролцоогүй цахим боловсруулалтаар мэдээллийн эзний эрх, ашигт нөлөөлөх шийдвэр гаргах, эсвэл хүний эмзэг мэдээллийг байнга боловсруулах зэрэг тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийлгэж болно.

Гуравдагч талтай хамтран ажиллах гэрээ

- Мэдээлэл хариуцагч мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг гэрээний үндсэн дээр мэдээлэл боловсруулагчид шилжүүлж болно.

Мэдээлэл хариуцагчийн хөтлөх бүртгэлүүд

- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны бүртгэл
- Мэдээлэл цуглуулах, боловсруулахад илэрсэн зөрчил, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээний бүртгэл

Зөвлөмж

- Хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотойгоор хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлж, Хүний эрхийн Үндэсний Комиссоос зөвлөмж авч болно.

Судалгааны ёс зүйн зөвшөөрөл (IRB (Institutional Review Board) approval)

- Хүний эмзэг мэдээлэл ашиглах, эмзэг бүлгийг хамарсан эсвэл эрсдэлтэй судалгаанд судалгааны ёс зүйн зөвшөөрөл авах шаардлага үүсэж болно.
- Энэхүү зөвшөөрлийг их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын ёс зүйн зөвлөлөөс олгодог. Тухайлбал, тус зөвшөөрлийг МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн дэргэдэх Судалгааны ёс зүйг магадлах зөвлөлөөс авах боломжтой.

3.

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ

САНАМЖ:

- Мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлийн хүрээнд цуглуулж, ашиглана.
- Мэдээллийг хамгийн бага түвшинд цуглуулж, илүү мэдээлэл цуглуулахаас зайлсхийнэ.



Судалгаанд оролцогчдоос мэдээлэл цуглуулахын өмнө мэдээллийн эзнээс "Мэдээлэлтэй зөвшөөрөл" авна.



Цуглуулсан мэдээллийг шалгаж, шаардлагатай бол шинэчлэх ба судалгаанд оролцогчдог буруу эсвэл дутуу мэдээллээ засах боломж олгоно.



Мэдээлэл цуглуулах явцад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангаж, зөвшөөрөлгүй хандалт, алдагдалаас хамгаална.

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ



Хувийн мэдээллийг цуглуулах явцад зөрчил илэрсэн тохиолдолд харцу арга хэмжээ авч, мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөхөөр бол гаруй мэдэгдэнэ.



Эмзэг хувийн мэдээлэл цуглуулах тохиолдолд нэмэлт хамгаалалт, нууцлал шаардлагатай.



Мэдээлэл цуглуулах явцад мэдээллийн эзэнд зөвшөөрлөө хүссэн үедээ хялбар цуцлах боломж бүрдүүлнэ.



Цуглуулсан мэдээллийг аюулгүй орчинд хадгалж, хувийн мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангаж, зөвшөөрөлгүй хандалт, алдагдалаас хамгаална.



Хувийн мэдээллийг хадгалах явцад зөрчил илэрсэн тохиолдолд хариу арга хэмжээ авч, мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөхөөр бол даруй мэдэгдэнэ.



Шаардлагатай тохиолдолд хувийн мэдээллийг хүнийг тодорхойлох боломжгүй болгон хадгална.

Мэдээллийн эзэн өөрийн мэдээлэлтэй танилцах, хуулбар авах боломж олгоно.



Мэдээлэл хадгалах төхөөрөмж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангаж, цаасан баримтыг аюулгүй орчинд хадгална.



ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАДГАЛАХ

Мэдээллийн эзэн мэдээллээ засуулах, устгуулах, хүсэлт, гомдол гаргах боломжоор хангана.



Судалгааны мэдээлэлд зөвхөн эрх бүхий судлаач хандах боломжтой болгон хандалтын эрхийг хязгаарлана.



Мэдээллийн эзний хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн, хариу мэдэгдэнэ.

Мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр мэдээллийг бусдад дамжуулахгүй.



Мэдээллийг зөвхөн шаардлагатай хугацаанд хадгална.



Судалгааны явцад мэдээллийн эзэнд зөвшөөрлөө хүссэн үедээ хялбар цуцлах боломж бүрдүүлнэ. Хэрэв мэдээллийг хүнийг тодорхойлох боломжгүй болгосон тохиолдолд судалгааны зорилгоор үргэлжлүүлэн ашиглаж болох бөгөөд энэ талаар мэдээллийн эзэнд мэдээлсэн байна.



4.

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ

Хувийн мэдээллийг зөвхөн мэдээллийн эзний зөвшөөрсөн хүрээнд боловсруулж ашиглана.

Мэдээлэл боловсруулах явцад мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангаж, зөвшөөрөлгүй хандалт, алдагдлагаас хамгаална.

Мэдээллийг өөр зорилгоор боловсруулж ашиглах бол дахин зөвшөөрөл авна.

Шаардлагатай тохиолдолд хувийн мэдээллийг хүнийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулна.

Мэдээлэл боловсруулах төхөөрөмж, системийн нууцлал, аюулгүй, тогтвортой ажиллагааг хангана.

САНАМЖ:

Мэдээллийг зөвхөн мэдээллийн эзний зөвшөөрсөн зорилгын хүрээнд ашиглана.

Мэдээлэл боловсруулах
явцад хандалтын эрхийг
хязгаарлана.

Гуравдагч этгээдээр
мэдээлэл боловсруулах
тохиолдолд
шаардлагатай
хамгаалалтын арга
хэмжээ авч, хяналт
хэрэгжүүлнэ.

Мэдээллийн эзний
хүсэлтийн дагуу
мэдээлэл боловсруулах,
ашиглах үйл
ажиллагааны талаар
мэдээлэл өгнө.

Мэдээллийн
эзэн өөрийн
мэдээлэлтэй
танилцах, хуулбар
авах боломж
олгоно.

Мэдээллийн эзэн
мэдээллээ засуулах,
устгуулах, хүсэлт,
гомдол гаргах
боломжоор хангана.

Хувийн мэдээллийг
боловсруулах явцад
зөрчил илэрсэн
тохиолдолд харуу арга
хэмжээ авч, мэдээллийн
эзний эрх, хууль ёсны
ашиг сонирхолд
нөлөөлөхөөр бол даруй
мэдэгдэнэ.

Мэдээллийн
эзний хүсэлт,
гомдлыг хүлээн авч
шийгвэрлэн, харуу
мэдэгдэнэ.

Судалгааны явцад мэдээллийн эзэнд
зөвшөөрлөө хүссэн үедээ хялбар
цуцлах боломж бүрдүүлнэ. Хэрэв
мэдээллийг хүнийг тодорхойлох
боломжгүй болгосон тохиолдолд
судалгааны зорилгоор үргэлжлүүлэн
ашиглаж болох бөгөөд энэ талаар
мэдээллийн эзэнд мэдээлсэн байна.

5.

ҮР ДҮНГ НИЙТЛЭХ, ХУВААЛЦАХ

- Судалгааны үр дүнг нийтлэхдээ оролцогчийг шууд болон шууд бусаар таних боломжтой хувийн мэдээллийг нийтлэхгүй.
- Судалгааны тайланд хүнийг ялгаварлан гадуурхах, нэр хүндэд нь сөргөөр нөлөөлөх мэдээлэл оруулахгүй.
- Судалгааны үр дүнг нийтлэх явцад зөрчил илэрсэн тохиолдолд хариу арга хэмжээ авч, мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөхөөр бол гаруй мэдэгдэнэ.
- Судалгааны үр дүнг оролцогчдын нууцлалыг хамгаалсан байдлаар буюу хувийн мэдээллийг хүнийг тодорхойлох боломжгүй болгон боловсруулсан нэгтгэсэн үр дүнг хуваалцана.
- Судалгаанд оролцогчдын зураг, ишлэл, кейс зэрэг танигдах мэдээлэл ашиглах бол тусгайлан зөвшөөрөл авна.
- Мэдээллийн эзний хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн, хариу мэдэгдэнэ.
- Судалгааны явцад мэдээллийн эзэнд зөвшөөрлөө хүссэн үедээ хялбар цуцлах боломж бүрдүүлнэ. Хэрэв мэдээллийг хүнийг тодорхойлох боломжгүй болгосон тохиолдолд судалгааны зорилгоор үргэлжлүүлэн ашиглаж болох бөгөөд энэ талаар мэдээллийн эзэнд мэдээлсэн байна.
- Судалгааны үр дүнг хувийн мэдээллийг цуглуулсан зорилгын хүрээнд ашиглаж, нийтэлнэ.
- Эмзэг хувийн мэдээлэл ашигласан бол илүү өндөр хамгаалалт хэрэгжүүлнэ.

СУДАЛГААНЫ
ҮР ДҮНГ
НИЙТЛЭХ

ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХУВААЛЦАХ, ДАМЖУУЛАХ

- Хувийн мэдээллийг бусдад дамжуулахдаа мэдээллийн эзнээс зөвшөөрөл авна.
- Мэдээллийг хуваалцах, дамжуулах үед зөрчил илэрсэн тохиолдолд харцу арга хэмжээ авч, мэдээллийн эзний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөхөөр бол даруй мэдэгдэнэ.
- Мэдээллийн эзний хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн, харцу мэдэгдэнэ.
- Хүнийг тодорхойлох боломжгүй болгосон мэдээллийг дахин ашиглах, хуваалцахдаа оролцогчийг таних эрсдэл бий эсэхийг үнэлнэ.
- Өгөгдлийг аль болох нэгтгэсэн болон таних боломжгүй хэлбэрээр хуваалцана.
- Эмзэг хувийн мэдээллийг таних боломжгүй болгосон ч оролцогчид сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй бол хуваалцахгүй байх арга хэмжээ авна.

6. ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ УСТГАХ

САНАМЖ:

- Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах үед мэдээлэл хадгалах хугацааг урьдчилан мэдэгдэнэ.
- Мэдээллийг хүнийг тодорхойлох боломжгүй хэлбэрт шилжүүлэхдээ хүнийг шууд болон шууд бусаар дахин таних эрсдэл бий эсэхийг нарийн шалгах шаардлагатай.
- Өгөгдлийг гуравдагч талд дамжуулсан бол тэдгээр байгууллага мөн мэдээллийг устгасан эсэхийг шалгана.

”

Хувийн мэдээллийг зөвхөн судалгааны зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хугацаанд хадгална.

Хадгалах хугацаа дуусмагц өгөгдлийг аюулгүй устгах эсвэл хүнийг тодорхойлох боломжгүй хэлбэрт шилжүүлэн нээлттэй өгөгдөл болгох, статистикийн мэдээлэл боловсруулах зэрэг зорилгоор ашиглаж болно.

Мэдээллийн эзэн мэдээллээ устгуулах хүсэлт гаргасан тохиолдолд хувийн **мэдээллийг устгах** арга хэмжээг авна.

ХҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ БОЛГОХ - НЭРГҮЙЖҮҮЛЭХ



Хүнийг тодорхойлох боломжгүй болгох гэдэг нь мэдээллийг тухайн хүнд огт хамааруулах боломжгүй болгохыг хэлнэ.

ШУУД ТАНИХ БОЛОМЖТОЙ

(Directly
identifiable)

Хүнийг **хэн бэ гэдгийг шууд тодорхойлох боломжтой** мэдээлэл.

Жишээ нь: Хүний овог нэр, регистрийн дугаар, цахим шуудан, хурууны хээ (биометрик мэдээлэл) болон гар утасны дугаар гэх мэт.

ШУУД БУС ТАНИХ БОЛОМЖТОЙ

(Indirectly
identifiable)

Дангаараа хүнийг шууд тодорхойлох боломжгүй ч бусад мэдээлэлтэй **нийлж тухайн хүнийг тодорхойлох боломжтой** мэдээлэл.

Жишээ нь: “Сүхбаатар дүүрэг, 12-р сургууль, сагсан бөмбөгийн багийн ахлагч, эрэгтэй сурагч” гэх мэдээллүүд нийлж, тухайн хүнийг хэн болохыг таних боломж олгоно.

НУУЦАЛСАН

(Pseudonymised)

Хүнийг шууд таних мэдээллийг код, token, hash гэх мэт аргаар **орлуулсан** мэдээлэл. Ингэснээр тухайн хүний жинхэнэ мэдээлэл шууд харагдахгүй болно. Гэхдээ кодыг тайлах нэмэлт мэдээлэл байгаа тохиолдолд тухайн хүнийг дахин таних боломжтой хэвээр байдаг. Тиймээс энэ нь хувийн мэдээлэлд тооцогдсон хэвээр байна.

Жишээ нь: хэрэглэгчийн нэрийг “Хэрэглэгч #A895” гэсэн кодоор сольж, кодын холбоос мэдээллийг тусгаа файлд хадгалах.

НЭРГҮЙЖҮҮЛСЭН

(Anonymised)

Хувь хүнийг таних боломжтой бүх мэдээллийг **бүрэн устгасан хэлбэр**. Ийм мэдээллийг тодорхой хүнтэй холбож таних боломжгүй. Тиймээс судалгааны үр дүн нийтлэх, статистик мэдээлэл бүрдүүлэх, нээлттэй өгөгдөл бий болгохдоо мэдээллийг нэргүйжүүлэх шаардлагатай.

Жишээ нь: “Судалгаанд оролцогчдын 60% нь ...”, насны дундаж, нэгтгэсэн статистик хүснэгт зэрэг нь хувь хүнийг таних боломжгүй тул хувийн мэдээлэлд хамаарахгүй.

МЭДЭЭЛЭЛТЭЙ ЗӨВШӨӨРӨЛ БОЛОВСРУУЛАХАД ЮУГ АНХААРАХ ВЭ?



Судалгааны байгууллага, судлаач хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахдаа мэдээллийн эзнээс “Мэдээлэлтэй зөвшөөрөл” авна.

САНАМЖ:

- 18-аас доош насны болон иргэний эрх зүйн чадамж нь хязгаарлагдсан иргэний хувьд түүний хууль ёсны төлөөлөгчөөс зөвшөөрөл авна.
- Мэдээллийн эзнээс зөвшөөрлийг цаасан эсвэл цахим хэлбэрээр бичгээр авна.
- Анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээллийг боловсруулах, ашиглах тохиолдолд мэдээллийн эзнээс дахин зөвшөөрөл авна.

МЭДЭЭЛЛИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ШААРДЛАГА

- Мэдээлэлтэй
- Сайн дурын
- Хүссэн үедээ цуцлах боломжтой

“МЭДЭЭЛЭЛТЭЙ ЗӨВШӨӨРӨЛ”-г юуг заавал мэдээлэх ёстой вэ?

- Мэдээлэл цуглуулах зорилго
- Ямар мэдээлэл цуглуулах
- Хэр хугацаанд хадгалах
- Мэдээллийг бусдад дамжуулах, нийтэд ил болгох эсэх
- Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хэрхэн хангах
- Судалгаанд оролцсоноор үүсэж болох эрсдэл, үр ашиг
- Мэдээллээ засах, устгуулах, зөвшөөрлөө цуцлах хэлбэр
- Мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих мэдээлэл



ТУНГААХУИ

- ӨГӨГДЛИЙН УРЛАН -